# Техник засварыг яаравчлан дуусгая

1963 оны газар тариалангийн үйлдвэрлэлийн бүх ажил өнгөрсөн намрын тариа хураалтаар шувтарч САА, МААМ станц, хөдөө аж ахуйн нэгдлүүдийн өмнө 1964 оны хаврын тариалтанд бэлтгэх ээлжит чухал зорилт тавигдаж байна.

Энэ ажлын үндсэн хэсэг нь хаврын тариалалтанд хэрэглэгдэх бүх трактор ХАА—н техникийг цаг алдалгүй чанартай засах тариалах үрээ бэлтгэх явдал билээ.

Гэтэл САА, ХАА—н нэгдлүүдэд тариалах үрийн дутууг олж бэлтгэх, байгаа үрээ цэвэрлэж дугаарлах, техникийн сэлбэг запасыг бэлтгэж засварыг дуусгах ажил удаашралтай явагдаж байна.

2 дугаар сарын 10—ны байдлаар тракторын 47,8, анжисны 62,4 үрлэгчийн 60,1, борнойн 71,2 хувь тус тус засварлагдаж бүх техникийн 55 хувь нь хаврын тариалалтанд бэлтгэгдээд байна.

Архуст, Батсүмбэрийн САА—нууд Эрдэнэсантын МААМ станц хаврын засварын бэлтгэлийг сайн хангаж засварыг цаг алдалгүй хийснээс тракторын 58 хувь, чиргүүл машины 85 хувийг засварлаж тариалах тариа ногооны үр ба засварыг 4 дүгээр сарын 1 ны дотор багтаан дуусгахаар зориг бадрангуй ажиллаж байна,

Батсүмбэр, Жаргалантын сангийн аж ахуй Эрдэнэсантын МААМ станцууд хавар зуны дулаан улиралд хаврын тариаланд шаардагдах ХАА—н чиргүүл, дүүжин машинуудынхаа ихэнхийг засварлаж амжсан нь өвлийн засварыг эрт дуусгах боломжтой болгож байна.

Жил ирэх дутам газар тариалангийн хэмжээ нэмэгдэн агротехникийн шаардлага, улам нарийсч ажлыг чадамгай зохион байгуулах явдал шаардагдаж байна.

Энэ оны өвлийн засвараар өнгөрсөн оныхоос хэдэн арван илүү тооны трактор, ХАА—н машин засварлах ба тарих үрийг цэвэрлэж хордуулахад хичнээн их хүч хөдөлмөр хэрэглэгдэх нь ил байна.

Намрын тариа хураалтын ажил дуусаад дариу 3 сар гаруй хугацаа өнгөрч байхад Баянцогт, Угтаалын сангийн аж ахуйнууд Баяндэлгэр, Сэргэлэнгийн МААМ станцуудын засварын ажил маш удаашралтай явагдаж байна.

Энэ нь тариа хураалтын ажил дуусмагц засварын ажлыг эхлүүлэхийн оронд бөөнөөр нь амралт чөлөө өгч явуулах засварын төлөвлөгөөг эртнээс гаргаж хэрэглэгдэх запасуудыг олж бэлтгээгүйгээс болж байна.

МАХН—ын Төв Хороо, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлөөс 1962 оны 4 дүгээр сард ХАА-н машин техникийн ашиглалт засвар хадгалалтыг сайжруулах талаар чухал тогтоол гаргасан билээ.

Уул тогтоолд засварыг зангилгааны аргаар хэсэгчлэн хийх тухай тодорхой заасан байна.

Ялангуяа засварын тохилог дулаан байртай аж ахуй,станцууд зангилгааны аргаар хэсэгчлэн засварлах давшилттай тэргүүний аргыг заавал хэрэглэх хэрэгтэй. Гэтэл зангилгааны аргыг хэрэглэх бололцоотой нилээд аж ахуй, станц давшилт аргыг үйлдвэрт нэвтрүүлэхгүй хуучныхаа, бригадын аргаар буюу эзэмшиж байгаа тракторчин нараар нь бүхэл бүтэн тракторыг засварлаж байна.

Зангилгаагаар нь хэсэгчлэн засварлахын тулд тракторыг үндсэн ба аслах мотоор, хурдын хайрцаг, явах анги, туслах анги, цахилгаан тоноглол гэх зэргээр хэд хэдэн зангилгаа болгож тус бүр дээр 4—5 хүнийг тогтмол ажиллуулах хэрэгтэй.

Ер нь хүмүүс нэг зангилгаан дээр тогтмол ажилладаг учир түүндээ түргэн мэрэгжиж улмаар засварын чанар сайжран хурдасдаг байна. Засварыг хир зэрэг чанартай хийсэн техник засварыг яаж ажиллуулсан зэргээс газар тариалангийн ажил шалтгаалдаг. Баянцогт, Батсүмбэрийн сангийн аж ахуй, Эрдэнсантын МААМ станцууд өнгөрсөн жил өвөл зуны техник засварыг сайн хийсний үрээр 1963 оны хаврын тариалалт намрын тариа хураалтын ажлыг богино хугацаанд дуусгалаа. Сангийн аж ахуй, станцууд юу юуны урьд одоо засварлагдаагүй байгаа хаврын тариалалтад ажиллах трактор чиргүүл, дүүжин машинуудыг энэ үлдэж байгаа богино хугацаанд нарийн хуваарь төлөвлөгөөтэй засварлуулах, хэрэглэгдэх сэлбэг хэрэглэгдүүний захилага тооцоог гарган яаралтай олж бэлтгэх явдал шаардагдаж байна.

Хаврын тариалалтанд ажиллах техник засварын ажилд нарийн зохион байгуулалттай орж, засварыг 3 дугаар сарын 20 нд чанартай дуусгаж хаврын тариалангийн бэлтгэл техник засварыг хүлээн авах комисст 100 хувь хүлээлгэн өхийн төлөө сангийн аж ахуй, МААМ станцын захиргааны дэргэдэх нам, олон нийтийн байгууллагууд бүх хүч бололцоогоо дайчлан ажиллаж социалист уралдааныг эрч далайцтай өрнүүлэх замаар энэ ажилд ажилчин олны идэвх хүчийг чиглүүлэх хэрэгтэй.

Н. Мишиг

# МАНАЙ СОНИНЫ МӨРӨӨР

Дэлгэрхаан сумын «Залуучуудын хөгжил» нэгдлийн авто машины жолооч Ч. Халзан, энгийн залуу Т. Отгон нарын ажил төрөлгүй болон архи ууж, агсан согтуу тавьж, нийтийн хэв журам зөрчсөн тухай «Анхдугаар таван жил» сонины 4, 7 дугаарт шүүмжлэгдсэн шүүмжлэлийн мөрөөр арга хэмжээ авсан тухай тус сумын эвлэлийн хорооны дарга Д. Сумъяа манайд хариу ирүүлэв. Нэгдлийн ерөнхий хороо,хуулийн байгууллага Ч. Халзан,Т.Отгон нарт тодорхой арга хэмжээ авч ажилгүй танхайрч явсан энгийн залуу Т. Отгонд нэгдлийн 200 гаруй хуц хариуцуулан маллуулжээ. Архи ууж агсан согтуу тавьж, хүний эрх чөлөөнд халдаж байсан авто машины жолооч Ч. Халзанг хуулийн байгууллагат шилжүүлэн шүүхийн хурлаар арга хэмжээ авчээ.

# Хөдөлмөрчдийн захидлын тойм

●Батсүмбэрийн сангийн аж ахуйн худалдаа бэлтгэлийн ангийн дэргэдэх ангийн нийгэмлэгийн гишүүн анчин Молом ан гэрээний ажлыг 13 наснаасаа эхлэн 54 нас хүртлээ хийж байгаа хүн.

Анчин Молом 1963 онд сумын хаа худалдаа бэлтгэлийн ангид зээрийн мах 123 кг, үнэг 15, чоно 1,тарвага 53,дорго 5,бугын эвэр 9 кг,зээрийн арьс 5,мануул нэгийг тушаажээ. Өвгөн анчин одоо 1964 онд зээрийн мах 50 кг чоно 1,үнэг 2—ийг тушаахаар амлалт үүрэг авч зээрийн мах 136 кг тушаагаад байна.

Ц.Дорж

●Баяндэлгэр сумын«Хэрлэн баян» нэгдлийн 2 дугаар бригадынхан 1 дүгээр улирлын хөлдүү түүхий эд бэлтгэлийн 41 нэр төрлийн зүйлээс 16 нэр төрлий нь 100—150 хувиар биелүүлж сумандаа тэргүүн байр эзлэж байна.Одоо дутуу байгаа бэлтгэлийн зүйлийг ойрын хугацаанд биелүүлэхээр зориг төгөлдөр ажиллаж байна.

Ш.Базарсад

●Бүрэн сумын худалдаа бэлтгэлийн анги 1964 оны 1 дүгээр улиралд чоно, үнэг агнах төлөвлөгөөг 100 хувь туулай,хярс агналтыг 110—122 хувиар тус тус биелүүлжээ.Агнуурын энэ ажилд анчин Доржпалам, Сандаг,Гунгаа нар бусдаасаа олон ан агнасан байна.

С.Дашдэндэв.

●Тариат сумын ХЗЭ-ийн үүрийн дарга Дамдиндоржоор удирдуусан цанын аялалынхан бригад суурнудаар орж нийтдээ 110 км аялажээ. Уг аялалынхан хэсэгчлэн концерт тоглож яриа танилцуулга хийсний дээр төллөх малын суурьт хөрзөн хороо нэгийг барьж өгчээ. Мөн хаваржааны чулуу түүж цэвэрлэж 2 дугаар бригадын хоньчин Аюушжавынд төлийн элгэвч 50 ширхэгийг бэлэглэсэн байна.

Г.Баасанжав

●Жаргалантын сангийн аж ахуйн 11 жилийн дунд сургуулийн 7 дугаар ангийн пионер сурагчид, өөрийн сургуулийн шеф Самбуу—ёндон ахлагчтай хонин суурь дээр очиж 2 өдөр ажиллаа.

Тэд хашаа засах, хот малтах, цас цэвэрлэх төл хүлээн авах байрыг нь дулаалах тэжээл татаж өгөх зэрэг ажилд туслалцлаа.

Б.Батмөнх

●Эрдэнсант сумын бага сургуулийн багш сурагчид цаны өргөн зугаалга хийлээ. Зугаалгын үеэр сургууль ба пионерийн бүлгэмийн цанын аврага шалгаруулав. Аврага шалгаруулах тэмцээнд 30 шахам пионер сурагчид оров.
4 дүгээр ангийн сурагч Мэдэхгүй, 2 дугаар ангийн Нэргүй нар 1,2 дугаар байр эзлэв.

●Алтанбулаг сумын «Монгол Согосын найрамдал» нэгдлийн гишүүн, анчин Бадам нэгдэлчдийнхээ баярыг угтаж үнэг 7, мануул 1—ийг агнаж арьсы нь сумычхаа худалдаа бэлтгэлийн ангид тушаав.

●. . . . дугаар их бууны анги онгоц ашиглалтын дэргэдэх үйлдвэрчний эвлэлийн бүлэг эмэгтэйчүүдийн хамт олон Алтанбулаг сумын «Монгол—Солонгосын найрамдал» нэгдлийн малчдад нэмнээ, элгэвч, уут, лаа, бээлий, шүдэнз саван зэргийг олон тоогоор бэлэглэв.

Г.Батхүү

●Алтанбулаг сумын 8 жилийн дунд сургууль төлийн бэлтгэлийг хангахад идэвхтэй туслаж байна. Саяхан хэсэг багш сурагчид төлийн бэлтгэл ажилд туслах 3 хоногийн ажил зохиож өөрийн шеф, богийн 2 дугаар бригадад очиж 500 хонины багтаамжтай тохилог сайхан хашаа 2-ыг барьж өгчээ.

Мөн төлийн бэлтгэлд зориулж 24 тонн өвс,8 тонн хөх бууц тataж өгсөний дээр хоньчин Цэдэн, Цэдэндорж, Цэрэндорж нарын суурийн 3 хашааг засч тохижууллаа. Төлчдөд зориулж суурь бүхэнд захидал бичиж төлийн уут, нэмнээ,угж,элгэвч,лаа,шүдэнз бэлэг болгож явууллаа.

Ш.Гунгаа

●Баянчандманий дундын засварын газрын ажилчны клубын дэргэдэх, хүүхдийн секц хүүхдийн дунд дуу, хөгжим, бүжиг,жижиг,кино, бөхийн зэрэг дугуйлангууд тогтмол хичээллэж сум бригадын төвд кино гаргаж жүжиг тоглож байна. Энэ секцийн хүүхдүүд Баянцогтын сангийн аж ахуйн төвд «Хүү» гэдэг драмын жүжиг тоглосон нь уран чадамгай болж үзэгч олны хайр талархлыг хүлээв.

Эд нар удахгүй Батсүмбэр,Борнуур, Жаргалантын сангийн аж ахуйнуудаар аялан явж тоглохоор бэлтгэж байна.

Д.Жамьян

●Баянцогтын сангийн аж ахуйд хөдөө аж ахуйн машин механизмын жолооч нарт мэргэжлийн зэрэг, үнэмлэх олгох улсын шалгалт явагдлаа.

Трактор камбайны жолоочоор 126 хүн шалгуулж 95,9 хувийн сурлагын дүн үзүүллээ.

Тракторч, комбайнч Нямдорж, механик Тогтох нар 1 дүгээр зэрэг, Цэдэвдамбаа, Баярсайхан, Очирсүх, боловсон хүчний эрхлэгч Бямбасүрэн нарын 6 хүн 2 дугаар зэргийн жолоочийн үнэмлэх авлаа.

Д. Содномдорж

*Сүхбаатарын нэрэмжит Эдийн Засгийн дээд сургуулийн хэсэг багш, оюутнууд өвлийнхөө амралтаар Угтаалцайдам сумын Залуучуудын нэрэмжит атрын сангийн аж ахуйд урлагаар үйлчлэв.

Залуучууд оюутны 2 дугаар их наадмын шагналт оюутан Должингийн дуулсан «Үлэмжийн чанар», «Баянмонгол» оюутан эмэгтэйчүүдийн найраг дуунууд үзэгчдэд ихэд таашаагдан тэдний талархал хүлээв.

Концертын дараа атрын сангийн аж ахуйн залуустай хамтран«нөхөрлөл»гэдэг өргөн үдэшлэг зохиов.

Ц.Гэндэн

Хариуцлагатай эрхлэгч

С. ДИНСМАА.

Х—03216

«Анхдугаар таван жил» сонины газар хэвлэв.

